

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан.

АУДИТЫН КОД: ДОА-2026/001/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2026 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4204, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn Ахлах аудитор: Ө.Сийлэгмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: siilegmaau@audit.gov.mn Аудитор: Б.Одхүү Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuu@audit.gov.mn Аудитор: Б.Оюунхэрлэн Утас: 7058-4207, Цахим хаяг: ouynkherlenb@audit.gov.mn Аудитор: С.Энхбаатар Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhaatars@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


АГУУЛГА

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	6
2.1 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	6
2.2 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	6
2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	7
2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	8
3. АУДИТЫН ТАЙЛАН	9
3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	9
3.1.1 Аудит хийсэн үндэслэл	9
3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ	9
3.1.3 Аудитын арга зүй	9
3.1.4 Материаллаг байдлын түвшин	9
3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ	10
3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж	10
3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн	10
3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР	10
3.3.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	10
3.3.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
3.3.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
3.3.4 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн мөнгөн гүйлгээний тайлан	11
4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	11
4.2 АВЛАГА	12
4.3 БАРАА	
МАТЕРИАЛ	14
4.4 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15
4.5 ӨР ТӨЛБӨР	15
4.6 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	16
4.7 ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ	17
4.8 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ	17
4.8.1 Худалдан авах ажиллагааны хэрэгжилт	17
4.8.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.9 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	18
4.10 ТЕЗ-ИЙН ХАМРАХ ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА	19
5.1 АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА	19
5.2 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ	20
5.2.1 АЛБАН ШААРДЛАГА	20
5.2.2 ЗӨВЛӨМЖ	21
5.3 САНАЛ:	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НА	Нийцлийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000 Утас: 7058-4203	ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Ш.ЁЛ ТАНАА
<u>2026.04.20</u> № <u>445</u> танай _____ -ны № _____ -т	
Хязгаарлалттай дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн нэгтгэсэн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.</p> <p style="text-align: center;">Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл</p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p>Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлөөс 4,387.7 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс 2,460.1 сая төгрөгөөр давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.</p> <p style="text-align: center;">Асуудлыг онцолсон хэсэг</p> <p>Тайлант онд Гурванзагал хөгжил, Хөлөнбуйр хөгжил, Өндөр хошуу хөгжил, Баянтүмэн хөгжил, Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ууд нь 2-3 жил дараалан алдагдалтай ажиллаж, Хулстай хөгжил ОНӨААТҮГ нь үйл ажиллагаа явуулаагүй Х тайлан ирүүлсэн. Мөн байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажилладаг "Байгаль хамгаалалтын захиргаа" ОНӨААТҮГ нь төсвөөс татаас авдаг бөгөөд 3 жил дараалан алдагдалтай ажиллаж байна</p> <p style="text-align: center;">Аудитын гол асуудал</p> <p>Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.</p>	

Авлага дансны үлдэгдэл 7,037.3 сая төгрөг байгаа бөгөөд үүний 49.3 хувь буюу 3,471.8 сая төгрөг нь 5-аас дээш жилийн насжилттай бөгөөд 69.3 хувь нь хугацаа хэтэрсэн байна.

Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт олгосон / Матад, Гурванзагал, Баянтүмэн / 45.7 сая төгрөгийн авлагатай байна.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн гэрээний дагуу "Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуй хөгжлийн хоёрдугаар үе шатны төсөл" МОН1907-ийн хүрээнд авсан 2,856.2 сая төгрөгийн зээлийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь Засгийн газарт төлсөн тул гэрээний дагуу "Дорнод НАА" ХХК-аас авахаар тусгасан ч тайлант хугацаанд төлбөр хийгдээгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 6 байгууллагуудад 112.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Жижиг мөнгөн сангийн хэмжээнээс хэтэрсэн дүнгээр байгууллагын нярвын харилцах дансаар бусдад өгөх тусламж, арга хэмжээ зохион байгуулах, бараа материал худалдан авах, шагнал урамшуулал, шатахуун авах зэргээр 120.0 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн.

Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.19-д орсон өөрчлөлтийн дагуу аймгийн Хөдөө аж ахуйн санг татан буулгаагүй байна.

Дорнод аймгийн Хэрлэн сумын ИТХ-ын 2025 оны 05/05 тогтоолоор "Чойбалсан хотын соёл, амралтын хүрээлэн" ОНӨААТҮГ-ыг шинээр байгуулсан, аймгийн ИТХ-ын 2025 оны 07/09 дугаар тогтоолоор Булган суман дахь сум дундын ойн анги, Чойбалсан сумын ИТХ-ын 2025 оны 37 дугаар тогтоолоор "Хулстай хөгжил" ОНӨААТҮГ нь тус тус татан буугдсан байна

Дорнод аймгийн ИТХ-ын хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 07/01 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг "Хангалттай" гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	35,527,362.4	48,689,873.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	22,180,037.1	33,830,475.8
33	АВЛАГА	6,872,666.0	7,037,346.0
35	БАРАА МАТЕРИАЛ	6,276,796.2	7,318,681.9
36	НӨӨЦИЙН БАРАА	197,863.2	456,184.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	164,062,035.8	190,990,307.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	164,062,035.8	190,990,307.5
39200	Биет хөрөнгө	150,143,539.5	176,604,810.0
39300	Биет бус хөрөнгө	13,918,496.4	14,385,497.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	199,589,398.3	239,680,181.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,195,446.8	10,295,060.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,195,446.8	10,295,060.6
41300	Өглөг	5,195,446.8	10,295,060.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	194,393,951.4	229,385,120.8
51	Засгийн газрын хувь оролцоо	194,393,951.4	229,385,120.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	33,576,488.5	33,503,202.5
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	10,947,809.6	9,762,828.1
51200	Хуримтлагдсан үр дүн	142,172,160.6	177,431,686.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,697,492.7	8,687,403.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	199,589,398.3	239,680,181.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	150,647,495.6	176,125,819.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	62,041,462.2	77,477,618.6
110	Орлогын албан татвар	45,963,125.8	59,062,224.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	40,655,195.4	42,694,349.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,391,872.4)	(1,763,520.4)
1103	ААН-ын орлогын албан татвар	6,699,802.9	18,131,395.6
113	Хөрөнгийн албан татвар	4,029,286.7	4,905,495.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	12,049,049.6	13,509,898.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	83,213,665.0	98,648,201.3
120	Нийтлэг татварын бус орлого	54,645,609.5	67,228,899.2
121	Хөрөнгийн орлого	42,731.9	55,755.6
122	Тусламжийн орлого	4,410,077.0	3,990,000.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	24,115,246.6	22,333,663.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,392,368.5	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	79,908,305.0	96,340,433.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	79,908,305.0	96,039,057.9

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	74,631,087.9	91,119,768.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,943,628.3	24,860,527.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,439,713.6	2,679,051.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,435,165.0	9,302,986.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,914,832.0	2,003,141.1
2105	Нормативт зардал	1,845,816.8	1,703,603.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,079,208.4	1,549,973.9
2107	Томилолт, зочны зардал	446,883.2	396,122.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,073,958.2	17,763,645.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,451,882.3	30,860,716.7
211	ХҮҮ	224,750.0	215,750.0
212	ТАТААС	62,784.0	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,989,683.1	4,703,539.0
214	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		301,375.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	70,739,190.7	79,785,386.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	42,990,432.9	45,073,654.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	27,748,757.8	34,711,732.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	166,524,876.3	0.0	166,524,876.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,382,466.0)	0.0	(3,382,466.0)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	163,142,410.3	0.0	163,142,410.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	3,368,531.9	0.0	3,368,531.9
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	110,494.2	0.0	110,494.2
9	Тайлант үеийн үр дүн	27,752,015.7	0.0	27,752,015.7
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	194,373,452.1	0.0	194,373,454.1
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	194,373,452.1	0.0	194,373,454.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,876,561.4)	0.0	(3,876,561.4)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,496,890.7	0.0	190,496,890.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	4,176,497.7	0.0	4,176,497.7
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	34,711,732.4	0.0	34,711,732.4
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	229,385,120.8	0.0	229,385,120.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	118,010,846.4	133,962,528.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	62,041,462.2	77,477,618.6
110	Орлогын албан татвар	45,963,125.8	59,062,224.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	40,655,195.4	42,694,349.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,391,872.4)	(1,763,520.4)
1103	ААН-ын орлогын албан татвар	6,699,802.9	18,131,395.6
113	Хөрөнгийн албан татвар	4,029,286.7	4,905,495.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	12,049,049.6	13,509,898.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,564,862.3	4,232,494.1
1181	Газрын төлбөр	3,754,846.9	4,255,799.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	5,729,340.4	5,021,604.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,044,843.4	56,484,909.6
120	Нийтлэг татварын бус орлого	22,491,732.9	28,862,126.2
121	Хөрөнгийн орлого	42,731.9	55,755.6
122	Тусламжийн орлого	4,395,132.0	5,233,364.8
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	24,115,246.6	22,333,663.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,924,540.8	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	69,497,544.3	81,265,949.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	69,497,544.3	81,265,949.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,217,437.8	76,346,660.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,000,670.3	29,032,212.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,365,467.8	2,671,324.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,244,650.8	9,925,525.6
2104	Хангамж, бараа материалын зардал	3,337,649.6	3,011,748.4
2105	Нормативт зардал	1,709,788.2	1,912,049.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	897,319.4	1,122,088.2
2107	Томилолт, зочны зардал	447,428.2	393,672.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,318,004.7	16,623,598.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,896,458.8	11,654,440.8
211	ХҮҮ	224,750.0	215,750.0
212	ТАТААС	62,784.0	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,992,572.5	4,703,539.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	48,513,302.1	52,696,578.4
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	43,657,262.9	39,782,690.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	43,657,262.9	39,782,690.1
2200	Дотоод эх үүсвэрээр	43,657,262.9	39,782,690.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(43,657,262.9)	(39,782,690.1)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(201,966.0)	(1,263,449.5)

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	40,000.0	1,263,449.5
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	161,966.0	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	4,654,073.2	11,650,438.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,525,963.9	22,180,037.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,180,037.1	33,830,475.8

3. АУДИТЫН ТАЙЛАН**3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ****3.1.1 Аудит хийсэн үндэслэл**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасныг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС, санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн эсэхэд дүгнэлт гаргаж, үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэсэн.

Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгуудад Аудитын олон улсын стандарт, Төрийн аудит MNS 6817-4:2020 Санхүүгийн аудитын тулгуур зарчимд заасны дагуу аудитын горим, сорилыг төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Төрийн аудитын байгууллага нь Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

3.1.3 Аудитын арга зүй

Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж үнэлгээ өгөв.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл, мөн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэл зэрэг асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайланд тусгасан.

3.1.4 Материаллаг байдлын түвшин

Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төсөл, хөтөлбөр, сан, орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэсэн тул материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үе шатанд Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 96,340.4 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 1,926.8 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

Дорнод аймгийн Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх заалтын дагуу Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 1/733 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагч хоорондын тооцоогоор ажил гүйлгээний давхардсан 189,852.7 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд цэвэрлэх бичилт хийсэн;
- Төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан байна.

Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 36 төсвийн шууд захирагчийн, 14 төрийн сан, 30 ОНТС, 23 орон нутгийн өмчит хуулийн этгээд, нийт 103 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж

Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлсэн байна.

3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны “finperform” программаар нэгтгэн гаргасан бөгөөд дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

А. Үндсэн тайлан	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Дорнод аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим 3-21 дүгээр тодруулгууд
Дорнод аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	1а, 1б, 2а, 2б, 3а, 3б, 5а, 5б, 6а, 6б, 7а, 8а, 8б, 8в, 9, 12а, 12б, 12в, 13, 15а, 15б, 17а, 17б тодруулга
Дорнод аймгийн Засаг даргын нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
Дорнод аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	

3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

3.3.1 Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 239,680.2 сая төгрөг болж, өмнөх оноос 20.1 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт №1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч

/мян.төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
---------------------	----------------	-----------------	--------------------------	-----------------

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Эргэлтийн хөрөнгийн дүн	35,527,362.4	48,689,873.9	13,162,511.5	20.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	164,062,035.9	190,990,307.5	26,928,271.6	79.7
Нийт хөрөнгийн дүн	199,589,398.3	239,680,181.4	40,090,783.1	100.0
Нийт өр төлбөр	5,195,446.9	10,295,060.6	5,099,613.8	4.3
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	194,393,951.4	229,385,120.8	34,991,169.4	95.7
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	199,589,398.3	239,680,181.4	40,090,783.1	100.0

Эх сурвалж: Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгө өмнөх оноос 40,090.8 сая төгрөгөөр өсөхөд тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг бүртгэл, тайланд тусгасан нь голлон нөлөөлжээ.

Өр төлбөр 5,099.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны сүүлд Сангийн яамнаас төрийн сангийн гүйлгээг хязгаарласнаас үүдэн ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн ажлуудын санхүүжилтийг гүйцэтгэгч компанид шилжүүлж амжаагүйтэй холбоотой байна.

3.3.2 Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 34,711.7 сая төгрөгөөр эерэг үзүүлэлттэй гарсан байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд 3,815.7 сая төгрөг, төсөвт байгууллагууд 23,113.3 сая төгрөг, ОНХС болон ХХС-гууд 2,262.9 сая төгрөг, сумдын ерөнхий орлогууд 10,045.6 сая төгрөгийн тус тус үр дүнтэй тайлагнасан байна.

3.3.3 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаар Засгийн газрын хувь оролцоо 34,991.2 сая төгрөгөөр, тайлант үеийн үр дүн 6,962.9 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

3.3.4 Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд мөнгөн орлого 133,962.5 сая төгрөг, зарлага 81,265.9 сая төгрөг, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 52,696.6 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй илэрхийлсэн байна.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 33,830.5 сая төгрөг болж, өмнөх оноос 11,650.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр

/мян. төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	342.0	570.6	228.6	-
Банканд байгаа бэлэн мөнгө	22,179,695.0	33,829,905.2	11,650,210.2	100.0
Дүн	22,180,037.1	33,830,475.8	11,650,438.7	100.0
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>				
ОНӨҮГ	697,811.1	967,247.9	269,436.80	2.9
Төрийн сан	14,821,053.6	24,968,797.4	10,147,743.80	73.8

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Төсөвт байгууллага	147,842.3	219,602.6	71,760.26	0.6
Төсөл/сан	6,513,330.1	7,674,827.9	1,161,497.80	22.7
Дүн	22,180,037.1	33,830,475.8	11,650,438.7	100.0

Эх сурвалж: Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 11,650.4 сая төгрөгөөр өсөхөд аймгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 13,060.0 сая төгрөг болж өмнөх оноос 10,408.6 сая төгрөгөөр өссөн нь гол нөлөөлсөн байна. Энэ нь ААН-ийн орлогын албан татвар төлөвлөгөөнөөс 7,711.4 сая төгрөгөөр давж биелсэнтэй холбоотой байна. ОНХС-гийн дансны үлдэгдэл 6,013.6 сая төгрөг болж өмнөх оноос 1,617.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны эцэст Сангийн яамнаас төрийн сангийн гүйлгээг хязгаарласнаас үүдэн ажил гүйцэтгэгч компаниудад санхүүжилтийг олгоогүйтэй холбоотой байна.

Орон нутгийн өмчит газруудын дансны үлдэгдэл болох 967.2 сая төгрөгийн 59.6 хувийг Дорнод Нийтийн аж ахуй ОНӨААҮГ-ын дансны үлдэгдэл эзэлж байна.

Харьяа байгууллагуудын илрүүлэлт:

1. Шатахууны зардлыг олгохдоо дээд шатны байгууллагаас баталсан Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дүгээр тушаалаар баталсан "Автомашинь 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг баримтлаагүй, 78.5 сая төгрөгийн зардал илүү олгосон 16 байгууллагад албан шаардлага хүргүүлсэн байна.
2. Ахмадын сангаас зарцуулалт хийхдээ холбогдох анхан шатны баримтуудыг хавсаргаагүй, нотлох баримт хангалтгүй 3.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 6.6 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлсэн байна.
3. Төрийн албаны тухай хуулийн дагуу 5 жилийн тэтгэмж олгохдоо 3.9 сая төгрөгийн ХХОАТ суутгаагүй 4 байгууллагад албан шаардлага хүргүүлсэн.
4. Гадаад томилолтод 9.0 сая төгрөгийн зардал олгосон 2 байгууллагад албан шаардлага хүргүүлсэн. /Хэрлэн сумын ИТХ, Аймгийн ЗДТГ/
5. Няравын хувийн дансаар дамжуулж гүйлгээ хийсэн 2 байгууллагад 120.0 сая төгрөгийн зөвлөмж өгсөн. /Халхгол ЗДТГ, Хэрлэн ЗДТГ/
6. Улзын хөгжил ОНӨААТҮГ нь байгууллагын бүх ажилчдад орон нутгийн нэмэгдэл болон төрийн албан хаагчийн нэмэгдэлд нийт 14.0 сая төгрөгийг олгосон зөрчсөнд төлбөрийн акт тогтоосон.
7. Булган сумын ЗДТГ нь тайлант жилд ажиллаагүй ажилтнуудад цалин олгосонд 3.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.
8. Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ нохой устгалын зардал хангалттай нотлох баримтгүй байсанд албан шаардлага хүргүүлсэн.
9. "Хөөвөр хөгжил" ОНӨААТҮГ-ын удирдлагын гэрээг дүгнээгүй байхад 2.5 сая төгрөгийн урамшуулал олгосонд, нягтлан бодогчид орон нутгийн нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, үр чадварын нэмэгдэл нийт 7.2 сая төгрөг олгосонд төлбөрийн акт тогтоосон.

4.2 АВЛАГА

Авлага дансны үлдэгдэл 7,037.3 сая төгрөг болж, өмнөх оноос 164.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Авлага дансны ангилал, байгууллагын төрлөөр

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	28,913.5	25,888.2	-3,025.3	0.4
Зээлийн хүүгийн авлага	50,802.7	54,353.1	3,550.4	0.8
Дансны авлага	77,049.0	16,137.6	-60,911.4	0.2
Татвар, НДШ-ын авлага	1,080.5	327.3	-753.2	-
Байгууллагаас авах авлага	1,739,687.1	2,381,907.9	642,220.9	33.8
Хувь хүмүүсээс авах авлага	1,984,111.8	1,617,135.0	-366,976.7	23.0

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	80,455.9	68,206.4	-12,249.5	1.0
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	54,327.4	17,152.3	-37,175.1	0.2
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	2,856,238.1	2,856,238.1	-	40.6
Дүн	6,872,666.0	7,037,346.0	164,680.0	100.0
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>				
ОНӨҮГ	773,739.3	493,218.4	-280,520.9	7.0
Төрийн сан	2,864,938.1	2,864,938.1	-	40.7
Төсөвт байгууллага	277,495.1	145,980.0	-131,515.1	2.1
Төсөл/ сан	2,956,493.6	3,533,209.6	576,716.1	50.2
Дүн	6,872,666.0	7,037,346.0	164,680.0	100.0

Эх сурвалж: Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдлийн 40.6 хувь буюу 2,856.2 сая төгрөг нь Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн гэрээний дагуу “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуй хөгжлийн хоёрдугаар үе шатны төсөл” МОН1907-ийн хүрээнд авсан зээлийг Засгийн газарт төлснийг гэрээний дагуу эцсийн зээлдэгч болох “Дорнод НАА” ОНӨҮГ-аас авах авлага, 47.4 хувийг Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага, 7 хувийг ОНӨҮГ-уудын авлага, 5 хувийг төсвийн шууд захирагч байгууллагуудын авлага эзэлж байна.

Авлага дансны үлдэгдлийн 40.6 хувь буюу 2,856.2 сая төгрөг нь Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн гэрээний дагуу “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуй хөгжлийн хоёрдугаар үе шатны төсөл” МОН1907-ийн хүрээнд авсан зээлийг Засгийн газарт төлснийг гэрээний эцсийн зээлдэгч болох “Дорнод НАА” ОНӨҮГ-аас авахаар үүсгэсэн авлага, 47.4 хувийг Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага, 7 хувийг ОНӨҮГ-уудын авлага, 5 хувийг төсвийн шууд захирагч байгууллагуудын авлага эзэлж байна.

Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн авлага болох 134.8 сая төгрөгийн авлага нь хөдөө аж ахуйн сангаас олгосон зээлийн авлага бөгөөд тайлант онд 49.4 сая төгрөгөөр буурч 85.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт авлагын 49.3 хувь буюу 3,471.8 сая төгрөг нь 5-аас дээш жилийн насжилттай бөгөөд 69.3 хувь нь хугацаа хэтэрсэн авлага байна.

Хүснэгт №1. Нийт авлагын насжилт, хугацаа хэтэрсэн байдал

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	Авлагын насжилтаар	Насжилтын дүнд эзлэх хувь	Хугацаа хэтэрсэн байдлаар	Хугацаа хэтэрсэн байдлын дүнд эзлэх хувь
0-1 жил	1,259,252.5	17.9	813,336.5	11.6
1-2 жил	349,925.1	5.0	126,438.4	1.8
2-3 жил	1,249,201.7	17.8	458,847.1	6.5
3-4 жил	614,943.6	8.7	9,880.4	0.1
4-5 жил	92,204.0	1.3	229,405.3	3.3
5-с дээш жил	3,471,819.1	49.3	3,241,786.5	46.1
Дүн	7,037,346.0	100.0	4,879,694.4	69.3

Эх сурвалж: Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Таваас дээш жилийн насжилттай авлагын 2,856.2 сая төгрөг нь дээр дурдсан “Дорнод НАА” ОНӨҮГ-аас авах авлага, 17.1 сая төгрөг нь мал хамгаалах сангийн авлага, 598.5 сая төгрөг нь хоршоо хөгжүүлэх сангийн авлага байна.

Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр үүсгэсэн 45.7 сая төгрөгийн авлагын 21.7 сая төгрөг буюу 47.5 хувь нь 2018 онд, 24.0 сая төгрөг буюу 52.5 хувь нь 2022 онд үүссэн байна.

Харьяа байгууллагуудын илрүүлэлт:

1. 14 сумдын ХХС-аас олгосон зээлийн хугацаа хэтэрсэн авлагад 535.0 сая төгрөгийн албан шаардлага, 697.5 сая төгрөгийн зөвлөмж өгч ажилласан.
2. Гурванзагал сумын ЗДТГ-т он дамжсан 24.0 сая төгрөгийн авлагад өмнөх оны аудитаар зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүйд албан шаардлага хүргүүлсэн.
3. Халхгол нэгдэл ОНӨААТҮГ нь санхүүгийн тайланд тусгаадаагүй НӨАТ-ын 15.5 сая төгрөгийн өр, ААНОАТ-ын 5.0 сая төгрөгийн өр, ХХОАТ-ын 1.9 сая төгрөгийн авлага нийт 22.5 сая төгрөгийг татварын албатай тооцоо нийлж баталгаажуулаагүйд албан шаардлага хүргүүлсэн.
4. Матад сумын ОНХС 40.1 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүйд албан шаардлага хүргүүлсэн.
5. Сэргэлэн сумын ОНХС-ийн 2014 онд үүссэн, олон жил дамжсан 18.7 сая төгрөгийн авлагын талаар Шүүхээс тухайн иргэнээс эргэн төлүүлэх шийдвэр гарсан ч шүүхийн захирамжийн дагуу авсан санхүүжилтээ буцаан төлөөгүйд зөвлөмж өгсөн.

4.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материал дансны үлдэгдэл 7,318.7 сая төгрөг болж, өмнөх оноос 1,041.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Бараа материал данс байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ОНӨҮГ	2,208,523.0	2,401,309.4	192,786.4	32.8
Төсөвт байгууллага	4,068,273.2	4,917,372.5	849,099.3	67.2
Дүн	6,276,796.2	7,318,681.9	1,041,885.7	100.0

Эх сурвалж: Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос нэмэгдэхэд аймгийн төсвөөс Баянтүмэн суманд цахилгаан дамжуулах агаарын шугам хийхэд шаардлагатай 555.7 сая төгрөгийн материал, Матад сумын ОНХС-гийн хөрөнгөөр малжуулах төсөл хэрэгжүүлсэн 149.1 сая төгрөгийн мал амьтдыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэл тайланд тусгасан зэрэг нь дараах хүчин зүйлс голлон нөлөөсөн байна.

Аудитын илрүүлэлт:

1. “Буйр нуурын экосистемийн хамгаалах, аялал жуулчлал хөгжүүлэх төв” болон “Байгаль хамгаалалтын захиргаа” ОНӨААТҮГ 2025 оны эхний хагас жилд бараа материалын тооллого хийгээгүйд, Худалдан авах ажиллагааны газар бараа материалын тооллогын бүртгэл үйлдээгүйд тус тус албан шаардлага хүргүүлсэн.
2. “Буйр нуурын экосистемийн хамгаалах, аялал жуулчлал хөгжүүлэх төв” болон “Байгаль хамгаалалтын захиргаа” ОНӨААТҮГ байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллаагүйд зөвлөмж өгсөн.
3. Баян-Уул сум дахь Сум дундын ойн анги блок материалыг зарлагадан хашаа барисан 5.1 сая төгрөгийг шууд зардалд бүртгэснийг, Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ худалдан авсан ажлын нормын хувцасны 5.2 сая төгрөгийг шууд зардалд бүртгэснийг тус тус залруулга хийлгэсэн.
4. Дорнод Нийтийн аж ахуй ОНӨААТҮГ: Бараа материалын шинж чанартай хөнгийг үндсэн хөрөнгөнд залруулга хийлгэсэн.

Нөөцийн бараа

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 456.2 сая төгрөг болж, өмнөх оноос 258.3 сая төгрөгөөр өссөн байна.

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Хүснэгт №1. Нөөцийн бараа данс байгууллагын төрлөөр

/мян. төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Нөөцийн бараа	197,863.2	456,184.6	258,321.4	100.0
Дүн	197,863.2	456,184.6	258,321.4	100.0

Эх сурвалж: Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 258.3 сая төгрөгөөр өссөн нь өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой өвс, тэжээлийн нөөц үүсгэсэнтэй холбоотой байна.

4.4 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл цэвэр дүнгээр 190,990.3 сая төгрөг болж, өмнөх оноос 26,928.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр

/мян. төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Биет хөрөнгө	150,143,539.5	176,604,810.1	26,461,270.6	92.5
Биет бус хөрөнгө	13,918,496.4	14,385,497.4	467,001.0	7.5
Дүн	164,062,035.9	190,990,307.5	26,928,271.6	100.0

Үүнээс: байгууллагын төрлөөр

ОНӨҮГ	73,692,337.6	77,725,153.3	4,032,815.7	40.7
Төсөвт байгууллага	90,369,698.3	113,265,154.2	22,895,455.9	59.3
Дүн	164,062,035.9	190,990,307.5	26,928,271.6	100.0

Эх сурвалж: Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 26,928.3 сая төгрөгөөр өссөн нь барилга байгууламжийн, тээврийн хэрэгслийн, машин тоног төхөөрөмжийн, тавилга эд хогшил, зам гүүр байгууламжийн, түүх, соёлын дурсгалт зүйлийн, дуусаагүй барилга, байгууламжийн, бусад үндсэн хөрөнгийн, программ хангамжийн, бусад биет бус хөрөнгийн дансанд тус тус хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдлийн 176,604.8 сая төгрөг буюу 92.5 хувийг биет хөрөнгө, 14,385.5 сая төгрөг буюу 7.5 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

1. "Дорнод Нийтийн аж ахуй" ОНӨААТҮГ-ийн үндсэн хөрөнгөнд 1.6 сая төгрөгийн үлдэх өртөгтэй зөөврийн компьютер бодитоор байхгүйд төлбөрийн акт тогтоосон.
2. "Чойбалсан хөгжил" ОНӨААТҮГ, Баян-Уул сум дахь Сум дундын ойн анги: Байгууллагын гэрчилгээ дээрх өмчийн дүн, санхүүгийн тайлан дээрх өмчийн дүнгээс зөрүүтэй илэрхийлэгдсэнд зөвлөмж өгсөн.
3. "Дорнод Нийтийн аж ахуй" ОНӨААТҮГ нь үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоогүйд зөвлөмж өгсөн. Үндсэн хөрөнгийн шинжтэй 2.9 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэснийг, үндсэн хөрөнгийн барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй 18.9 сая төгрөгийн цэвэр усны шугамыг зохих шийдвэргүйгээр бусад үндсэн хөрөнгөнд шилжүүлж бүртгэснийг, Орон нутгийн өмчийн газар нь үндсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг дутуу бүртгэснийг, жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв ОНӨААТҮГ нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн шугам засварын ажлыг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд худалдаж авсан хөрөнгөөр тайлагнасныг тус тус залруулга хийлгэсэн.

4.5 ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 10,295.1 сая төгрөг болж, өмнөх оноос 5,099.6 сая төгрөгөөр өссөн байна.

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Хүснэгт №1. Нийт өр төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр /мян. төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	282.1	2,014.0	1,731.9	0.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	28,079.9	16,402.1	(11,677.8)	0.2
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	6,092.5	381,867.0	375,774.5	3.7
Зээлийн хүүгийн өглөг	4,143,656.9	4,143,656.9	(0.0)	40.2
Байгууллагад төлөх өглөг	1,013,105.7	5,720,103.9	4,706,998.2	55.6
Хувь хүмүүст төлөх өглөг	2,854.1	11,490.0	8,635.9	0.1
Татварын өглөг	1,375.6	8,424.4	7,048.8	0.1
НДШ-ийн өглөг	-	9,346.3	9,346.3	0.1
Дансны өглөг	-	1,756.0	1,756.0	0.0
Дүн	5,195,446.8	10,295,060.6	5,099,613.8	100.0
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>				
ОНӨҮГ	4,935,445.8	5,428,130.9	492,685.1	52.7
Төрийн сан	32.4	32.4	0.0	0.0
Төсөвт байгууллага	259,968.6	4,866,897.3	4,606,928.7	47.3
Дүн	5,195,446.8	10,295,060.6	5,099,613.8	100.0

Эх сурвалж: Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны нийт өр төлбөрийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 5,099.6 сая төгрөгөөр өссөн нь Сангийн яамнаас төсвийн зардлын гүйцэтгэлд тавьсан хязгаарлалтын улмаас аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 664.6 сая төгрөгийн өглөг, аймгийн ОНХС-гаар 545.7 сая төгрөгийн өглөг, сумдын ОНХС-гаар 3,471.6 сая төгрөгийн өглөг тус тус үүссэн байна.

Нийт өр төлбөрийн 5,428.1 сая төгрөг буюу 52.7 хувийг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын, 4,866.9 сая төгрөг буюу 47.3 хувийг төсөвт байгууллагын өр төлбөр эзэлж байна.

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой газрын өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 5,428.1 сая төгрөг болж, өмнөх оноос 492.7 сая төгрөгөөр өссөн нь Дорнод Нийтийн аж ахуй ОНӨААТҮГ-ын хог хаягдлын үйлчилгээний төлбөрийн, НДШ-ийн, ДБЭХС ТӨХК-д төлөх өглөгтэй холбоотой байна.

Хүснэгт №1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр /мян. төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Дорнод аймгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв	467.3	1394.1	926.8	0.0
Дорнод нийтийн аж ахуй ОНӨҮГ	4,639,440.7	5,203,061.2	563,620.5	95.9
Дорнод аймгийн Чойбалсан хөгжил үйлчилгээ ОНӨҮГ	18,562.4	7,659.8	(10,902.6)	0.1
Дорнод аймгийн Хэрлэн тохижилт үйлчилгээ ОНӨҮГ	-	2415	2,415.0	0.0
Дорнод аймгийн Дашбалбар хөгжил ОНӨҮГ	172.2	121.03	(51.2)	0.0
Дорнод аймгийн Халхгол нэгдэл ОНӨҮГ	93,743.4	671.9	(93,071.5)	0.0
Дорнод аймгийн Эрэнцав хөгжил ОНӨҮГ	-	41625.4	41,625.4	0.8
Дорнод аймгийн Сумдын Эмийн эргэлтийн сан	181,285.9	154,532.5	(26,753.4)	2.8
Дорнод аймгийн Хөлөнбуйр хөгжил ОНӨҮГ	-	16,650.0	16,650.0	0.3
Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөл	1,773.9	0	(1,773.9)	0.0
Дүн	4,935,445.8	5,428,130.9	492,685.1	100.0

Эх сурвалж: Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4.6 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 229,385.1 сая төгрөг болж, өмнөх оноос 34,991.1 сая төгрөгөөр өссөн байна.

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Хүснэгт №1. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	<i>/мян. төгрөгөөр/</i>	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	33,576,488.5	33,503,202.5	-73,286.0	14.6
Эздийн өмчийн бусад хэсэг	10,947,809.6	9,762,828.1	-1,184,981.5	4.3
Хуримтлагдсан үр дүн	142,172,160.6	177,431,686.3	35,259,525.7	77.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,697,492.7	8,687,403.9	989,911.2	3.8
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	194,393,951.4	229,385,120.8	34,991,169.4	100.0
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>				
ОНӨҮГ	70,695,997.5	76,430,770.5	5,734,773.0	33.3
Төсөвт байгууллага	96,633,252.4	118,485,128.0	21,851,875.6	51.7
Төсөл, сан	10,239,238.5	8,693,303.1	-1,545,935.4	3.8
Төрийн сан	16,825,463.0	25,775,919.2	8,950,456.2	11.2
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	194,393,951.4	229,385,120.8	34,991,169.4	100.0

Эх сурвалж: Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 5,734.8 сая төгрөгөөр, төсөвт байгууллага 21,851.9 сая төгрөгөөр, төрийн сан 8,950.4 сая төгрөгөөр нэмэгдэж, төсөл сан 1,545.9 сая төгрөгөөр буурсан байна.

4.7 ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаагүй, үр дүн гүйцэтгэлийг тайлагнаагүйгээс ТЕЗ-ийн хамрах хүрээний байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 112.0 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 15.0 сая төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 97.0 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлсэн.

4.8 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.8.1 Худалдан авах ажиллагааны хэрэгжилт

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хэрэгжилтийг ханган ажиллаагүй Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 4 өмчит хуулийн этгээдэд 660.3 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлсэн.

4.8.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.9 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Дорнод аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 80 хувийн гүйцэтгэлтэй байна.

4.10 ТЕЗ-ИЙН ХАМРАХ ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 36 төсвийн шууд захирагчийн, 30 орон нутгийн тусгай сангийн, 14 төсвийн төвлөрүүлэн захирагчийн, 23 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нийт 68 төсөв захирагч нарын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 38 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, аудитын үе шатны ажлыг гүйцэтгэн 41 "Өөрчлөлтгүй", 23 "Хязгаарлалттай", 1 "Татгалзсан" санал дүгнэлтийг өгч ажиллалаа.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 6,559.0 сая төгрөгийн 83 алдаа илэрснийг залруулсан.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 3,566.4 сая төгрөгийн 153 зөрчил илэрснээс 152.1 сая төгрөгийн 35 төлбөрийн акт, 1,374.6 сая төгрөгийн 79 албан шаардлага, 1,998.7 сая төгрөгийн 37 зөвлөмж, 40.9 сая төгрөгийн зөрчил гаргасан 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж ажиллалаа.

Мөн шилэн дансны тухай хуулийг зөрчсөн нийцлийн асуудлаар нийт 7,229.7 сая төгрөгийн 23 зөрчил илэрснээс 5,935.5 сая төгрөгийн 14 албан шаардлага, 1,110.9 сая төгрөгийн 8 зөвлөмж, 183.3 сая төгрөгийн зөрчил гаргасан 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн байна.

Төсөвт байгууллага

Аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 36 төсвийн захирагчийн санхүүгийн тайлан хамрагдаж 23 төсвийн захирагчийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж /өөрчлөлтгүй 18, хязгаарлалттай 5/, 13 төсвийн захирагчийн санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, аудитын үе шатны ажлыг гүйцэтгэсэн.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 3,246.8 сая төгрөгийн 55 алдаа илэрснийг залруулсан.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 783.7 сая төгрөгийн 83 зөрчил илэрснээс 61.3 сая төгрөгийн 23 төлбөрийн акт, 531.5 сая төгрөгийн 45 албан шаардлага, 162.7 сая төгрөгийн 14 зөвлөмж, 28.2 сая төгрөгийн зөрчил гаргасан 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж ажиллалаа.

Мөн шилэн дансны тухай хуулийг зөрчсөн нийцлийн асуудлаар нийт 6,526.6 сая төгрөгийн 13 зөрчил илэрснээс 5,718.6 сая төгрөгийн 9 албан шаардлага, 624.7 сая төгрөгийн 6 зөвлөмж, 183.3 сая төгрөгийн зөрчил гаргасан 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн байна.

Орон нутгийн тусгай сан

Аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 30 орон нутгийн тусгай сангийн санхүүгийн тайлан хамрагдаж 4 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт гаргаж, 2 санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгч, 24 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, аудитын үе шатны ажлыг гүйцэтгэсэн.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 1,129.9 сая төгрөгийн 10 алдаа илэрснийг залруулсан.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 2,098.3 сая төгрөгийн 27 зөрчил илэрснээс 19.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 605.0 сая төгрөгийн 18 албан шаардлага, 1,474.0 сая төгрөгийн 8 зөвлөмж өгсөн.

Орон нутгийн өмчит хуулийн этгээд

Аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 23 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан хамрагдаж 22 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж /өөрчлөлтгүй 14, хязгаарлалттай 7, татгалзсан^{1/}, 1 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, аудитын үе шатны ажлыг гүйцэтгэсэн.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 2,129.5 сая төгрөгийн 17 алдаа илэрснийг залруулсан.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 361.4 сая төгрөгийн 34 зөрчил илэрснээс 71.7 сая төгрөгийн 11 төлбөрийн акт, 214.1 сая төгрөгийн 15 албан шаардлага, 62.9 сая төгрөгийн 7 зөвлөмж өгч, 12.7 сая төгрөгийн 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн.

Мөн Шилэн дансны тухай хуулийг зөрчсөн нийцлийн асуудлаар нийт 152.5 сая төгрөгийн 3 зөрчил илэрснээс 152.5 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

Чойбалсан сумын “Хулстай хөгжил” ОНӨҮГ нь 2025 онд үйл ажиллагаа огт явуулаагүй, “Х”-тайлан ирүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагч, төрийн сан

Аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 14 сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан хамрагдаж, өөрчлөлтгүй 5, хязгаарлалттай 9 санал, дүгнэлт өгч ажиллалаа.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 52.8 сая төгрөгийн 1 алдаа илэрснийг залруулсан.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 323.0 сая төгрөгийн 9 зөрчил илэрснээс 23.9 сая төгрөгийн 1 албан шаардлага, 299.1 сая төгрөгийн 8 зөвлөмж өгч ажиллалаа.

Мөн Шилэн дансны тухай хуулийг зөрчсөн нийцлийн асуудлаар 1 албан шаардлага, 560.6 сая төгрөгийн 6 зөвлөмж өгч ажиллалаа.

5 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА

5.1 АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА

Аудитаар нийт 1,962.6 сая төгрөгийн 9 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Дашбалбар сумын ХХС нь 136.0 сая төгрөгийн зээл олгохдоо Үр дүнгийн тайланд зардлаар бүртгэн тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Баянтүмэн сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 102.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.2-т “*бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага*” гэснийг зөрчсөн, санхүүгийн тайлангийн *иж бүрэн байх* гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Дашбалбар сумын ЗДТГ нь 2021 онд ДБЭХС ТӨХК-д шилжсэн Аят багийн 24.2 сая төгрөгийн ЦДАШ-ыг данс бүртгэлээс хасаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.1 “*аж ахуйн бүх ажил, гүйлгээ*”, санхүүгийн тайлангийн *тасалбар болголт* гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Дашбалбар сумын ЗДТГ нь 2021 онд ДБЭХС ТӨХК-д шилжсэн 24.2 сая төгрөгийн ЦДАШ-нд 9.2 сая төгрөгийн элэгдэл тооцсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.1 “*аж ахуйн бүх ажил, гүйлгээ*”, санхүүгийн тайлангийн *тасалбар болголт* гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Дашбалбар сумын ЗДТГ нь 2021 онд ДБЭХС ТӨХК-д шилжсэн Чух багийн 67.6 сая төгрөгийн ЦДАШ-ыг данс бүртгэлээс хасаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.1 “*аж ахуйн бүх ажил, гүйлгээ*”, санхүүгийн тайлангийн *тасалбар болголт* гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Дашбалбар сумын ЗДТГ нь 2021 онд ДБЭХС ТӨХК-д шилжсэн 67.6 сая төгрөгийн хөрөнгөнд 4.0 сая төгрөгийн элэгдэл тооцсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.1 “*аж ахуйн бүх ажил, гүйлгээ*”, санхүүгийн тайлангийн *тасалбар болголт* гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Хөрөнгө оруулалтын ажлын 664.2 сая төгрөгийн өглөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн *үнэлгээ ба хуваарилалт* гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Баян-Уул сумын ИТХ нь 0.6 сая төгрөгийг зардлын ангилал буруу тусган илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.7-д “*нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс*” гэснийг зөрчсөн, санхүүгийн тайлангийн *ангилал* гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгийн данс бүртгэлд анхны өртгөө бүрэн нөхсөн 278 ширхэг 953.4 сая төгрөгийн хөрөнгөнд дахин үнэлгээ хийлгэж тайлан бүртгэлд тусгуулсан.

5.2 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт 85.4 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 85.4 сая төгрөгийн 2 албан шаардлага, 7 зөвлөмж өгч ажиллалаа. Үүний 3 зөвлөмж нийцлийн асуудалтай холбоотой.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 3,636.9 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын зөрчил бөгөөд энэ нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,709.3 сая төгрөгөөр давж, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул *Хязгаарлалттай* дүгнэлт өглөө.

5.2.1 АЛБАН ШААРДЛАГА

1. Дорнод аймгийн Засаг даргын 2018 оны А/48 дугаар захирамжаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Дэлхийн нягтлан бодогчдын холбооны

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дэргэдэх Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (УСНББОУСЗ)-өөс 2021 онд шинээр баталсан болон нэмэлт өөрчлөлт оруулсан УСНББОУС болон шинээр батлагдсан хууль тогтоомж, дүрэм журам, заавартай нийцэхгүй, өөрчлөлт хийх талаар өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу Хөдөө аж ахуйн санг татан буулгаагүй, тухайн сангаас олгосон зээлийн авлагын үлдэгдэл 85.4 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2.2 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

ДОРНОД АЙМГИЙН ИТХ-Д

Илрүүлэлт 1 Тайлант онд Гурванзагал хөгжил, Хөлөнбуйр хөгжил, Өндөр хошуу хөгжил, Баянтүмэн хөгжил, Халхгол нэгдэл ОНӨААТҮГ-ууд нь 2-3 жил дараалан алдагдалтай ажиллаж, Хулстай хөгжил ОНӨААТҮГ нь үйл ажиллагаа явуулаагүй Х тайлан ирүүлсэн. Мөн байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажилладаг "Байгаль хамгаалалтын захиргаа" ОНӨААТҮГ нь төсвөөс татаас авдаг бөгөөд 3 жил дараалан алдагдалтай ажиллаж байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн анх байгуулсан зорилгоо биелүүлээгүй, үйл ажиллагаа доголдсон шалтгаан нөхцөл, засаглалыг сайжруулахад хяналтыг хэрэгжүүлэн дүн шинжилгээ хийж, татан буулгах үндэслэл бүрдсэн эсэхийг тогтоож, үр дүнг шийдвэрлүүлэх.

Илрүүлэлт 2 Аймгийн хэмжээнд байгаль орчныг хамгаалах чиглэлээр 14 сумын ЗДТГ-т 3 орон тоотой байгаль орчны тасаг, 3 сум дундын ойн анги, 3 суманд Сав газрын захиргаа ажиллаж байгаа боловч "Байгаль хамгаалалтын захиргаа" ОНӨААТҮГ, болон "Буйр нуурын экосистемийг хамгаалах аялал жуулчлал хөгжүүлэх төв" ОНӨААТҮГ-ыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн ажиллуулж байгаа нь УИХ-ын 2024 оны 54 дүгээр тогтоолоор баталсан "бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: УИХ-ын 2024 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган алдагдалтай ажиллаж байгаа Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах.

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД

Илрүүлэлт 1 Авлага дансны үлдэгдэл 7,037.3 сая төгрөг болж, өмнөх оноос 164.6 сая төгрөгөөр өссөн байна. Үүний 2,856.2 сая төгрөг буюу 40.6 хувь нь Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн, 3,281.2 сая төгрөг буюу 46.6 хувь нь ХХС-аас олгосон зээлийн авлагын үлдэгдэл эзэлж байна. ХХС-гийн нийт авлагын 24.9 хувь буюу 832.1 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн байна.

Өгсөн зөвлөмж: Сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт, зээлийн эргэн төлөлтөд дүн шинжилгээ хийж, хугацаа хэтэрсэн авлагыг 35 хувиар бууруулж, чанарын зээлийн зохистой харьцааг ханган ажиллах.

Илрүүлэлт 2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаагүй, үр дүн гүйцэтгэлийг тайлагнаагүйгээс ТЕЗ-ийн хамрах хүрээний байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 112.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Илрүүлэлт 3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудад санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,636.9 сая төгрөгийн 211 алдаа, зөрчил илэрсэн.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжид дүн шинжилгээ хийж, төсвийн захирагч, нягтлан бодогч нарыг мэргэжлийн арга зүйгээр хангах, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх.

Илрүүлэлт 4 Аймгийн Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эрхийг жил бүр Засаг даргын захирамжаар эрх шилжүүлдэг бөгөөд 2025 онд Засаг даргын А/35 дугаар захирамжаар дээрх арга хэмжээг санхүүжүүлэх эрхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргад шилжүүлэн хэрэгжүүлж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заасан “төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасантай нийцэхгүй байна. Мөн орон нутгийн төсвөөс олгож буй санхүүжилтийг аймгийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлж байгаа бөгөөд аймгийн Засаг даргын А/34 дүгээр захирамжаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эрхийг Засаг даргын Тамгын газрын даргад шилжүүлсэн байна. Энэхүү эрх шилжүүлсэн захирамж нь аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүргийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчид шилжүүлэх хууль зүйн үндэслэл болохгүй. Түүнчлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийн хоёрдугаар гарын үсгийг төсвийн шууд захирагчийн нягтлан бодогчоор зуруулж байгаа нь холбогдох хууль, журмын шаардлагад нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Хууль, тогтоомжид нийцүүлэх.

Илрүүлэлт 5 Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудад хийсэн Санхүүгийн тайлангийн аудитаар шилэн данс болон бусад хууль тогтоомжийн нийцэлтэй холбоотой нийт 23,569.4 сая төгрөгийн 74 зөрчил илэрсэн байна.

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

5.3 САНАЛ:

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлого 22,933.7 сая төгрөг шилжүүлэхээс 600.0 сая төгрөгөөр дутуу шилжүүлсэн нь Сангийн яам дахин хуваарилалтыг төсвийн жилд багтаан орон нутагт шилжүүлээгүйтэй холбоотой байна. Иймд Сангийн яаманд нэгтгэсэн тайланд ОНХНС-ийн орлогын дахин хуваарилалтыг төсвийн жилд багтаан орон нутагт шилжүүлж байх зөвлөмжийг тусгуулах

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” гэж заасан. Харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 11 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Алдааны товч утга	Нийт алдаа		Үүнээс									
			Тоо	Мөнгөн дүн	Мэдээллийг		Буруу тусган		НББ-ийн		Залруулсан		Залруулаагүй	
					Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Дорнод аймгийн Баянтүмэн сумын Засаг дарга	Барилгын сайжруулалтыг санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгаагүй орхигдуулсан байна.	1.0	52.8	1.0	52.8					1.0	52.8		
2	Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Өглөгийн дансанд НДШ-ын залруулга хийсэн	1.0	0.2	1.0	0.2					1.0	0.2		
		Шатах тослох материалын зарлагад залруулга хийлгэсэн	1.0	29.9			1.0	29.9			1.0	29.9		
3	Дорнод аймгийн Баян-Уул сумын Засаг даргын тамгын газар	БМ-д хөрөнгийн эд анги тус бүрээр бүртгэж тайлагнасан	1.0	4.1			1.0	4.1			1.0	4.1		
		БМ-д үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэж тайлагнасан	1.0	13.9			1.0	13.9			1.0	13.9		
		Цалингийн хүснэгт, НДШ тайлан, ХХОАТ-ын тайланд зөрүүтэй дүнгээр тайлагнасан	1.0	0.8			1.0	0.8			1.0	0.8		
4	Дорнод аймгийн Баяндун сумын Засаг даргын тамгын газар	Бараа материалд хөрөнгийн ангиллыг хольж бүртгэн тайлагнасан	1.0	3.7			1.0	3.7			1.0	3.7		
		Бараа материалд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэж тайлагнасан	1.0	238.1			1.0	238.1			1.0	238.1		
		Цалингийн хүснэгт, НДШ тайлан, ХХОАТ-ын тайланд зөрүүтэй дүнгээр тайлагнасан	1.0	3.3			1.0	3.3			1.0	3.3		
		Үндсэн хөрөнгөд капиталжуулах өртгийг бусад нь хөрөнгөөр бүртгэж тайлагнасан	1.0	304.8			1.0	304.8			1.0	304.8		
5	Дорнод аймгийн Баянтүмэн сумын Засаг даргын тамгын газар	БМ-ыг шийдвэргүй данснаас хассан.	1.0	555.7	1.0	555.7					1.0	555.7		
		Бараа материалын орлогыг буруу дансанд бүртгэж орлого бууруулсан.	1.0	0.1					1.0	0.1	1.0	0.1		
		Нэмэлт харилцааар данс андуурч орсон орсон орлогыг үндсэн дансанд төвлөрүүлэхдээ орлогын данс бууруулах журналын бичилт хийсэн. /дт /	1.0	0.9			1.0	0.9			1.0	0.9		
		Санхүүгийн байдлын тайланд хасах үлдэгдэлтэй өр төлбөр тайлагнасан	1.0	3.5			1.0	3.5			1.0	3.5		
6	Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын тамгын газар	Бараа материалын ангилал хооронд хольж бүртгэн тайлагнасан	1.0	10.9			1.0	10.9			1.0	10.9		
		Цалингийн хүснэгт, НДШ тайлан, ХХОАТ-ын тайланд зөрүүтэй дүнгээр тайлагнасан	1.0	1.6			1.0	1.6			1.0	1.6		
		БМ-ыг шууд зардалд бүртгэсэн	1.0	0.3			1.0	0.3			1.0	0.3		
7	Дорнод аймгийн Гурванзагал сумын Засаг даргын тамгын газар	БМ-ын үдэгдэлтэй байсан зарлага болгох аж ахуйн материал тайлагнасан	1.0	0.6			1.0	0.6			1.0	0.6		
		Бараа материалын ангилал хооронд бүртгэж тайлагнасан.	1.0	18.0			1.0	18.0			1.0	18.0		
		Анхан шатны баримтыг эх хувиар тулгасан	1.0	18.0			1.0	18.0			1.0	18.0		
		ҮХ-нд ашиглах хугацаагүй, нэр төрөл тодорхой бус хөрөнгө бүртгэлтэй	1.0	5.1			1.0	5.1			1.0	5.1		
8	Дорнод аймгийн Дашбалбар сумын Засаг даргын тамгын газар	Бараа материалд нөөцийн барааг бүртгэж тайлагнасан	1.0	29.9			1.0	29.9			1.0	29.9		
		Бараа материалд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэж тайлагнасан	1.0	23.5			1.0	23.5			1.0	23.5		
		Цалингийн хүснэгт НДШ тайлан, ХХОАТ-ын тайланд зөрүүтэй дүнгээр тайлагнасан	1.0	0.9			1.0	0.9			1.0	0.9		
9	Дорнод аймгийн Матад сумын Засаг даргын тамгын газар	Санхүүгийн тайланд тусгаагүй ажил гүйлгээ.	1.0	18.5	1.0	18.5					1.0	18.5		
10	Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газар	капиталжуулах засварын зардлыг үндсэн хөрөнгөнд тусдаа бүртгэсэнээс шалтгаалж хөрөнгийн үлдэгдэлд үлдсэнийг шилжүүлэх	1.0	64.9			1.0	64.9			1.0	64.9		
11	Дорнод аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын тамгын газар	Бараа материалд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэж тайлагнасан	1.0	8.4			1.0	8.4			1.0	8.4		
		Бараа материалын ангиллыг буруу ангилан бүртгэж тайлагнасан тохирч байна	1.0	4.9			1.0	4.9			1.0	4.9		
		Цалин, НДШ тайлан, ХХОАТ-ын тайлангууд зөрүүтэй тайлагнасан байна.	1.0	3.4			1.0	3.4			1.0	3.4		

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

12	Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын тамгын газар	Үндсэн хөрөнгөнд бүртгэгдсэн Өв соёлын өргөө хашааны санхүүжилтийг биет бус хөрөнгө рүү капиталжуулан бүртгэх	1.0	19.7			1.0	19.7			1.0	19.7		
		Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгөнд бүртгэгдэх зураг төсвийн капиталжуулах зардлыг үндсэн хөрөнгөөр бүртгэж элэгдэл тооцсон	1.0	320.9			1.0	320.9			1.0	320.9		
13	Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газар	Бараа материалын дансны бүртгэлд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан	1.0	50.4			1.0	50.4			1.0	50.4		
		Үндсэн хөрөнгөнд биет бус хөрөнгөнд бүртгэгдэх зураг төсвийн капиталжуулах зардлыг үндсэн хөрөнгөөр бүртгэж элэгдэл тооцсон	1.0	134.0			1.0	134.0			1.0	134.0		
14	Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Засаг даргын тамгын газар	Бараа материал шууд зарлага болгож тайлагнасан	1.0	0.7			1.0	0.7			1.0	0.7		
		Бараа материалын ангилал хооронд хольж зөрүүтэй бүртгэж тайлагнасан	1.0	63.1			1.0	63.1			1.0	63.1		
		Цалингийн хүснэгт, НДШ тайлан зөрүүтэй тайлагнасан	1.0	10.9			1.0	10.9			1.0	10.9		
		Үндсэн хөрөнгийг ангилал хольж бүртгэсэн	1.0	158.6			1.0	158.6			1.0	158.6		
15	Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	Зардлын ангилал зөрүүлсэн.	1.0	142.5			1.0	142.5			1.0	142.5		
		Зардлын ангилал зөрүүлсэн.	1.0	16.9			1.0	16.9			1.0	16.9		
		Бичиг хэрэг ангилалд худалдан авсан материалыг БМ-ын тайланд буруу тусгасан.	1.0	0.6			1.0	0.6			1.0	0.6		
		Зардлын ангилал тохирохгүй гүйлгээ хийсэн	1.0	0.1			1.0	0.1			1.0	0.1		
		ҮХ-ын тайлангийн ангилал зөрүүтэй	1.0	0.5			1.0	0.5			1.0	0.5		
16	Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Засаг даргын тамгын газар	Бараа материалд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг тайлагнасан	1.0	13.3			1.0	13.3			1.0	13.3		
		Бараа материалын ангилал хооронд хольж бүртгэн тайлагнасан	1.0	37.1			1.0	37.1			1.0	37.1		
		Цалингийн хүснэгт НДШ тайлан зөрүүтэй тайлагнасан	1.0	4.1			1.0	4.1			1.0	4.1		
		Үндсэн хөрөнгөд ангилал холилдсон хөрөнгүүд бүртгэлтэй	1.0	158.3			1.0	158.3			1.0	158.3		
17	Дорнод аймгийн Чойбалсан сумын Засаг даргын тамгын газар	Бараа материалд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бүртгэж тайлагнасан	1.0	75.1			1.0	75.1			1.0	75.1		
		Бараа материалын ангилал хооронд бүртгэж тайлагнасан	1.0	115.0			1.0	115.0			1.0	115.0		
		ЗД-ын 2025.04.09-ны өдрийн А/32 захирамжаар 3,500,000 төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд тодотголоор 5,000,000 төгрөгөөр нэмэгдэж нийт 8,500,000 төгрөгөөс гүйцэтгэлээр 5,876,100 төгрөгийг шилжүүлсэн ба зургаар баталгаажаагүй	1.0	5.9			1.0	5.9			1.0	5.9		
		Цалингийн хүснэгт, НДШ тайлан зөрүүтэй тайлагнасан	1.0	0.5			1.0	0.5			1.0	0.5		
		Үндсэн хөрөнгөд ангилал хооронд хольж бүртгэн тайлагнасан	1.0	422.5			1.0	422.5			1.0	422.5		
18	Дорнод аймгийн Чулуунхороот сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	Аудитын явцад санхүүгийн тайланд залруулж тусгуулах	1.0	0.1	1.0	0.1					1.0	0.1		
19	Чулуунхороот сумын Засаг даргын тамгын газар	Бараа материалд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгүүдийг бүртгэж тайлагнасан	1.0	28.1			1.0	28.1			1.0	28.1		
		Бараа материалын ангилал хооронд бүртгэж тайлагнасан	1.0	18.8			1.0	18.8			1.0	18.8		
		Цалингийн хүснэгт, НДШ тайлан зөрүүтэй тайлагнасан	1.0	1.3			1.0	1.3			1.0	1.3		
		Үндсэн хөрөнгөд ангилал хольж бүртгэн тайлагнасан	1.0	79.9			1.0	79.9			1.0	79.9		
20	Дорнод аймгийн Баяндун сумын Орон нутгийн хөгжлийн сан	Өр төлбөрийн үлдэгдлийг хасах дүнтэй, төрийн сан дахь харилцахын үлдэгдлийг дутуу тайлагнасан,	1.0	128.4			1.0	128.4			1.0	128.4		

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

21	Дорнод аймгийн Баяндун сумын Хоршоо хөгжүүлэх сан	Сангаас олгосон эргэж төлөгдөх зээлийг авлагад бүртгээгүй, үр дүнгийн тайланд зардлаар бүртгэсэн.	1.0	132.8			1.0	132.8			1.0	132.8		
22	Дорнод аймгийн Баянтүмэн сумын Орон нутгийн хөгжлийн сан	Сургуулийн спорт заалны барилга /төсөвт өртөг 2,746.7 сая төгрөг/-ын ажилд 2025 онд сумын ОНХС-аас 575.0 сая төгрөгийг тус тус олгож, шууд зардлаар бүртгэсэн байна.	1.0	575.0			1.0	575.0			1.0	575.0		
23	Дорнод аймгийн Халх гол сумын Орон нутгийн хөгжлийн сан	Хөрөнгө шамшигдах нөхцөл байдал үүсэх	1.0	75.0					1.0	75.0	1.0	75.0		
24	Дорнод аймгийн Халх гол сумын Орон нутгийн хөгжлийн сан	Шилжих хөрөнгийн гүйцэтгэлтэй холбоотой дуусаагүй 3 төсөл арга хэмжээнд урьдчилж олгосон зардлыг нягтлан бодох бүртгэлийн дагуу бүртгээгүй.	1.0	47.2					1.0	47.2	1.0	47.2		
25	Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Орон нутгийн хөгжлийн сан	Гүйцэтгэгч талд өгөх өглөгийг дутуу тусгасан	1.0	40.5			1.0	40.5			1.0	40.5		
26	Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Орон нутгийн хөгжлийн сан	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг үндсэ хөрөнгөнд бүртгээгүй зардлаар тайлагнасан.	4.0	131.0	4.0	131.0					4.0	131.0		
27	Дашбалбар хөгжил ОНӨҮГ	Наадмын талбай өргөтгөх шинэчлэх ажлын 457,994.3 мянган төгрөгийн хөрөнгийг дуусаагүй барилгад бүртгээгүй	1.0	458.0	1.0	458.0					1.0	458.0		
		ОНХС-аас орж ирсэн санхүүжилтийг зөрүүтэй олгосноос зарцуулсан зардлыг орлогын дэлгэрэнгүй тайланд тусгаж залруулав.	1.0	20.0			1.0	20.0			1.0	20.0		
		Үндсэн хөрөнгийн сайжруулалт дансанд бүртгэхдээ харьцсан дансыг буруу сонгосныг бусад орлогоор бүртгэж залруулав.	1.0	136.7			1.0	136.7			1.0	136.7		
		Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг хойшлогдсон татварын ерөөр буруу тусгасныг бусад орлогоор залруулав. Өмнөх онд шилжиж ирсэн хөрөнгийн элэгдлийг бүртгэхдээ хойшлогдсон татварын хөрөнгө дансанд бүртгэснийг өмнөх үеийн хуримтлагдсан үр дүн дансанд тусган залруулав.	1.0	799.9			1.0	799.9			1.0	799.9		
28	Дорнод аймгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв ОНӨҮГ	Орон нутгийн төсвийн санхүүжилтийг төсвийн байгууллагын өөрийн орлогоор тайлагнасан	1.0	241.8							1.0	241.8		
		Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн шугам засварын ажлыг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд худалдаж авсан хөрөнгөөр тайлагнасан	1.0	177.6							1.0	177.6		
		Тайлан гаргахдаа татварын байгууллагатай тооцоо нийлээгүй, татварын өглөгийг тайланд тусгаагүй байна.	1.0	0.9							1.0	0.9		
29	Дорнод нийтийн аж ахуй ОНӨҮГ	Шийдвэргүйгээр хөрөнгийн данс хооронд шилжүүлсэн.	1.0	19.0			1.0	19.0			1.0	19.0		
		Бараа материалын шинж агуулсан хөрөнгийг үндсэн хөрөнгөнд орлого авч бүртгэсэн.	1.0	19.0			1.0	19.0			1.0	19.0		
		Компьютерыг бараа материалын дансанд бүртгэсэн.	1.0	2.9			1.0	2.9			1.0	2.9		
30	Сэргэлэн хөгжил ОНӨҮГ	ХХОАТ-ыг ААНОАТ-ын төрлөөр бүртгэсэн	1.0	0.5			1.0	0.5			1.0	0.5		
		Үндсэн хөрөнгийн элэгдлийг 194,700.0 мянган төгрөгөөр илүү тооцсон	1.0	194.7			1.0	194.7			1.0	194.7		
31	Хэрлэн тохижилт үйлчилгээ ОНӨҮГ	БМ-ыг шууд зардалд бүртгэсэн	3.0	26.7			3.0	26.7			3.0	26.7		
32	Чойбалсан хөгжил ОНӨҮГ	БМ-ыг шууд зардалд бүртгэсэн	1.0	5.2	1.0	5.2					1.0	5.2		
НИЙТ ДҮН			83.0	6,559.0	11.0	1,221.3	66.0	4,795.1	3.0	122.3	83.0	6,559.0	-	-

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Зөвлөмж		Албан шаардлага		Төлбөрийн акт		Хариуцлага тооцуулах	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Дорнод аймгийн Баян-Уул сумын Засаг дарга	1	32.3	1	32.3		-				
2	Дорнод аймгийн Баянтүмэн сумын Засаг дарга	1	-	1	-		-				
3	Дорнод аймгийн Гурванзагал сумын Засаг дарга	2	16.6	2	16.6		-				
4	Дорнод аймгийн Дашбалбар сумын Засаг дарга	2	222.3	2	222.3		-				
5	Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Засаг дарга	1	3.7	1	3.7		-				
6	Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Засаг дарга	1	23.9		-	1	23.9				
7	Дорнод аймгийн Чойбалсан сумын Засаг дарга	1	24.3	1	24.3		-				
8	Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	1	4.1		-	1	4.1				
9	Дорнод аймгийн Баян-Уул сумын ЗДТГ	2	4.3		-	2	4.3				
10	Дорнод аймгийн Баяндун сумын ЗДТГ	5	7.6	1	0.5	3	5.7	1	1.4		
11	Дорнод аймгийн Баянтүмэн сумын ЗДТГ	4	18.9		-	2	18.5	2	0.4		
12	Дорнод аймгийн Баянтүмэн сумын ИТХ	1	-		-	1	-		-		
13	Дорнод аймгийн Булган сумын ЗДТГ	4	12.8		-	2	8.9	2	3.9		
14	Дорнод аймгийн Булган сумын ИТХ	1	-	1	-		-		-		
15	Дорнод аймгийн Гурванзагал сумын ЗДТГ	5	57.5	2	22.0	2	34.5	1	1.0		
16	Дорнод аймгийн Дашбалбар сумын ЗДТГ	3	201.3	1	16.6	2	184.7		-		
17	Дорнод аймгийн Дашбалбар сумын ИТХ	1	4.0		-		-	1	4.0		
18	Дорнод аймгийн ЗДТГ	5	45.3		-	2	9.9	2	7.2	1	28.2
19	Дорнод аймгийн ИТХ	1	0.5		-		-	1	0.5		
20	Дорнод аймгийн Матад сумын ЗДТГ	2	4.7		-	2	4.7		-		
21	Дорнод аймгийн Матад сумын ИТХ	2	16.4		-	2	16.4		-		
22	Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газар	2	4.3		-	1	3.4	1	0.9		
23	Дорнод аймгийн Сэргэлэн сумын ЗДТГ	4	7.8		-	2	6.5	2	1.3		
24	Дорнод аймгийн Халхгол сумын ЗДТГ	8	108.4	1	40.9	4	61.1	3	6.4		
25	Дорнод аймгийн Халхгол сумын ИТХ	3	1.4	1	-	1	0.9	1	0.5		
26	Дорнод аймгийн Худалдан авах ажиллагааны газар	1	2.6		-	1	2.6		-		
27	Дорнод аймгийн Хэрлэн сумын ЗДТГ	10	217.1	1	79.1	6	106.1	3	31.9		
28	Дорнод аймгийн Хэрлэн сумын ИТХ	3	19.7		-	2	18.3	1	1.4		
29	Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын ЗДТГ	1	7.1		-	1	7.1		-		
30	Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын ИТХ	1	0.1		-		-	1	0.1		
31	Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын ЗДТГ	3	6.6	2	-	1	6.6		-		
32	Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын ИТХ	2	0.7	1	-	1	0.7		-		
33	Дорнод аймгийн Чойбалсан сумын ЗДТГ	2	19.1		-	2	19.1		-		
34	Дорнод аймгийн ахмадын хороо	2	0.4	1	-		-	1	0.4		
35	Дорнод аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	1	-	1	-		-		-		
36	Чулуунхороот сумын ЗДТГ	3	10.9	1	3.5	2	7.4		-		
	ТШЗ дүн	92	1,106.7	22	461.8	46	555.4	23	61.3	1	28.2

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

1	Дорнод аймгийн Баян - Уул сумын Хоршоо хөгжүүлэх сан	2	22.8	1	1.4	1	21.4		-		
2	Дорнод аймгийн Баяндун сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	40.3			1	40.3		-		
3	Дорнод аймгийн Баянтүмэн сумын Хоршоо хөгжүүлэх сан	2	83.9			1	64.8	1	19.1		
4	Дорнод аймгийн Булган сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	16.8			1	16.8		-		
5	Дорнод аймгийн Гурванзагал сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	20.0			1	20.0		-		
6	Дорнод аймгийн Дашбалбар сумын Хоршоо хөгжүүлэх сан	3	139.4	1	20.6	2	118.8		-		
7	Дорнод аймгийн Матад сумын ОНХС	1	40.1			1	40.1		-		
8	Дорнод аймгийн Матад сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	66.7			1	66.7		-		
9	Дорнод аймгийн ОНХС	1	1,190.0	1	1,190.0		-		-		
10	Дорнод аймгийн Сэргэлэн сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	105.3			1	105.3		-		
11	Дорнод аймгийн Халх гол сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	32.5			1	32.5		-		
12	Дорнод аймгийн Хэрлэн сумын Хоршоо хөгжүүлэх сан	5	279.6	3	262.0	2	17.6		-		
13	Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Орон нутгийн хөгжлийн сан	2	9.8			2	9.8		-		
14	Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Хоршоо хөгжүүлэх сан	2	12.7	1	-	1	12.7		-		
15	Дорнод аймгийн Чойбалсан сумын ОНХС	1	6.1			1	6.1		-		
16	Дорнод аймгийн Чойбалсан сумын Хоршоо хөгжүүлэх сан	2	32.3	1	-	1	32.3		-		
	ОНТС дүн	27	2,098.3	8	1,474.0	18	605.1	1	19.1	-	-
1	Баянтүмэн хөгжил ОНӨҮГ	1	65.1			1	65.1		-		
2	Буйр нуурын экосистемийг хамгаалах, аялал жуулчлал хөгжүүлэх төв ОНӨҮГ	3	9.2	1	-	2	9.2		-		
3	Гурванзагал хөгжил ОНӨҮГ	2	-	2	-		-		-		
4	Дашбалбар хөгжил ОНӨҮГ	4	76.0			2	42.0	2	34.0		
5	Дорнод аймгийн Байгаль хамгаалалтын захиргаа ОНӨҮГ	3	13.8	1	-	1	12.3	1	1.6		
6	Дорнод аймгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв ОНӨҮГ	1	-			1	-		-		
7	Дорнод нийтийн аж ахуй ОНӨҮГ	3	37.2			1	32.1	2	5.1		
8	Сэргэлэн хөгжил ОНӨҮГ	1	0.4			1	0.4		-		
9	Улзын хөгжил ОНӨҮГ	1	14.0				-	1	14.0		
10	Халхгол нэгдэл ОНӨҮГ	4	45.5	1	0.9	3	44.6		-		
11	Хэрлэн тохижилт үйлчилгээ ОНӨҮГ	1	2.0				-	1	2.0		
12	Хөлөнбуйр хөгжил ОНӨҮГ	2	6.0	1	-	1	6.0		-		
13	Хөөвөрхөгжил ОНӨҮГ	2	9.6				-	2	9.6		
14	Чойбалсан хөгжил ОНӨҮГ	4	19.3			1	1.2	2	5.4	1	12.7
15	Эрэнцав хөгжил ОНӨҮГ	1	62.0	1	62.0		-		-		
16	Өндөрхошуу хөгжил ОНӨҮГ	1	1.3			1	1.3		-		
	ОНӨҮГ дүн	34	361.4	7	62.9	15	214.1	11	71.7	1	12.7
	Нийт дүн	153	3,566.4	37	1,998.7	79	1,374.6	35	152.1	2	40.9

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН


Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт		Зөвлөмж		Албан шаардлага		Хариуцлага тооцуулах	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Дорнод аймгийн Баяндун сумын Засаг дарга	1	-	1	-				
2	Дорнод аймгийн Баянтүмэн сумын Засаг дарга	1	-	1	-				
3	Дорнод аймгийн Баянтүмэн сумын ЗДТГ	1	52.4	1	52.4				
4	Дорнод аймгийн Булган сумын Засаг дарга	2	60.4	1	-	1	60.4		
5	Дорнод аймгийн Булган сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	112.2	1	112.2				
6	Дорнод аймгийн Дашбалбар сумын Засаг дарга	1	-			1	-		
7	Дорнод аймгийн Матад сумын Засаг дарга	1	-	1	-				
8	Дорнод аймгийн Сэргэлэн сумын Засаг дарга	2	-	2	-				
9	Дорнод аймгийн Халхгол сумын Засаг дарга	5	320.9	4	260.8	1	60.1		
10	Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг дарга	2	71.7			2	71.7		
11	Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Засаг дарга	2	-	2	-				
12	Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Засаг дарга	1	-	1	-				
13	Дорнод аймгийн Чойбалсан сумын Засаг дарга	1	-	1	-				
14	Дорнод аймгийн Чулуунхороот сумын Засаг дарга	2	572.4	2	572.4				
15	Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	1	1,012.9			1	1,012.9		
16	Дорнод аймгийн Баян-Уул сумын Засаг даргын тамгын газар	1	-	1	-				
17	Дорнод аймгийн Баяндун сумын Засаг даргын тамгын газар	2	842.1	1	-	1	842.1		
18	Дорнод аймгийн Баяндун сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	3.4	2	3.4				
19	Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын тамгын газар	3	171.5	1	-	1	171.5	1	-
20	Дорнод аймгийн Гурванзагал сумын Засаг даргын тамгын газар	3	802.8	1	-	1	798.9	1	3.9
21	Дорнод аймгийн Гурванзагал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	183.2					1	183.2
22	Дорнод аймгийн Дашбалбар сумын Засаг даргын тамгын газар	2	2,037.0	1	-	1	2,037.0		
23	Дорнод аймгийн Дашбалбар сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	-			1	-		
24	Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар	3	6.7	3	6.7				
25	Дорнод аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	732.4			2	732.4		
26	Дорнод аймгийн Матад сумын Засаг даргын тамгын газар	3	688.5	1	-	1	686.7	1	1.8
27	Дорнод аймгийн Матад сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	466.8	1	466.8				
28	Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газар	1	547.1			1	547.1		
29	Дорнод аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	1	2,182.6	1	2,182.6				
30	Дорнод аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын тамгын газар	2	-	1	-			1	-
31	Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын тамгын газар	2	19.7	1	19.7	1	-		
32	Дорнод аймгийн Халхгол сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	-	1	-	1	-		
33	Дорнод аймгийн Халхгол сумын Сум дундын ойн анги	1	-			1	-		
34	Дорнод аймгийн Худалдан авах ажиллагааны газар	4	19.1	2	0.3	2	18.7		
35	Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газар	2	13.6	2	13.6				
36	Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	-	1	-				
37	Дорнод аймгийн Хэрлэн сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	27.9	1	27.9				
38	Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Засаг даргын тамгын газар	3	340.1	1	-	1	340.1	1	-
39	Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	41.5	1	41.5				
40	Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Засаг даргын тамгын газар	2	109.8	1	-	1	109.8		
41	Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	83.5	1	83.5				
42	Дорнод аймгийн Чойбалсан сумын Засаг даргын тамгын газар	2	9.0	2	9.0				
43	Дорнод аймгийн Чулуунхороот сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	5.9	1	5.9				
44	Дорнод аймгийн ахмадын хороо	1	74.4	1	74.4				
45	Чулуунхороот сумын Засаг даргын тамгын газар	2	1.0	1	-			1	1.0
46	Дорнод аймгийн Баян-Уул сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	142.9	1	142.9				
47	Дорнод аймгийн Баянтүмэн сумын Орон нутгийн хөгжлийн сан	2	153.0			2	153.0		
48	Дорнод аймгийн Гурванзагал сумын Орон нутгийн хөгжлийн сан	2	181.6	1	116.2	1	65.4		
49	Дорнод аймгийн Гурванзагал сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	51.9	1	51.9				
50	Дорнод аймгийн Матад сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	190.4			1	190.4		
51	Дорнод аймгийн Матад сумын Хоршоо хөгжүүлэх сан	4	78.0	4	78.0				
52	Дорнод аймгийн Сэргэлэн сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	18.7	1	18.7				
53	Дорнод аймгийн Халамжийн сан	1	-	1	-				
54	Дорнод аймгийн Халх гол сумын Орон нутгийн хөгжлийн сан	2	203.6			2	203.6		
55	Дорнод аймгийн Хэрлэн сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	734.8	1	734.8				
56	Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Орон нутгийн хөгжлийн сан	3	180.2	2	72.3			1	107.9
57	Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	-	1	-				
58	Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Орон нутгийн хөгжлийн сан	2	1,473.3	1	177.9	1	1,295.4		
59	Дорнод аймгийн Чойбалсан сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	180.0	1	180.0				
60	Дорнод аймгийн Чулуунхороот сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	105.0	1	105.0				
61	Баянтүмэн хөгжил ОНӨҮГ	1	-			1	-		
62	Буйр нуурын экосистемийг хамгаалах, аялал жуулчлал хөгжүүлэх төв ОНӨҮГ	3	-	3	-				
63	Дашбалбар хөгжил ОНӨҮГ	2	527.6	1	431.8	1	95.8		
64	Дорнод аймгийн Байгаль хамгаалалтын захиргаа ОНӨҮГ	3	-	3	-				
65	Дорнод аймгийн Баян-Уул суман дахь сум дундын ойн анги ОНӨҮГ	2	97.8	2	97.8				
66	Дорнод нийтийн аж ахуй ОНӨҮГ	6	5,290.6	4	2,162.6	2	3,128.0		
67	Наранбулаг хөгжил ОНӨҮГ	1	74.1	1	74.1				
68	Сэргэлэн хөгжил ОНӨҮГ	3	118.9	2	108.7	1	10.2		
69	Улзын хөгжил ОНӨҮГ	2	25.3			2	25.3		

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

70	Халхгол нэгдэл ОНӨҮГ	3	938.1	1	-	2	938.1		
71	Хэрлэн тохижилт үйлчилгээ ОНӨҮГ	2	84.3	1	-	1	84.3		
72	Хөлөнбуйр хөгжил ОНӨҮГ	1	-	1	-				
73	Хөөвөрхөгжил ОНӨҮГ	1	162.5	1	162.5				
74	Чойбалсан хөгжил ОНӨҮГ	4	192.0	2	21.2	2	170.8		
75	Эрээнцав хөгжил ОНӨҮГ	3	422.8	3	422.8				
76	Өндөрхошуу хөгжил ОНӨҮГ	3	465.3	3	465.3				
Нийт дүн		142	23,705.3	93	9,557.6	41	13,849.9	8	297.8



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**


2026 оны 04 сарын 20 өдөр Дугаар А/162 Чойбалсан хот

Г Г

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 2025 оны А/175 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Дорнод аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газарт хүргүүлэхийг аудитын менежер (Д.Нармандах)-д даалгасугай.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэхийг Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга (Г.Цолмон), Засаг дарга (Ш.Ёл)-д зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Ө.Сийлэгмаа)-д үүрэг болгосугай.



Б.БОЛОРТУУЛ

2125020045